

**МАНЖ ЧИН УЛСААС ДӨРВӨДИЙН ХАН СОНОМГОМБО,
МАГСАРЖАВ НАРЫН ХАТАНД ОЛГОСОН ӨРГӨМЖЛӨЛ**

Э.ЖИГМЭДДОРЖ

МУИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D.)

Товч агуулга: Энэ өгүүлэлд Манж Чин улсаас Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогт, Магсаржавын их хатан залахус овогтон нарт олгосон навчит өргөмжлөлийг судлан шинжлэхийг зорив. Манжийн хааны зарлигаар Монгол ноёдын хатан нарт өргөмжлөл олгохдоо язгууртны цол, хэргэм болон хатны уг язгуур, төрөлх зан чанарыг харгалзан үздэг аж. Манжийн төрөөс өргөмжлөл хүртсэн Монголын язгууртан ноёдын хатад тухайн үеийн засаг бус тайж нарын хатан болон бусад эмэгтэйчүүдээс дээгүүр байр суурь эзэлж, нийгмийн дээд давхрагад хамаарч байжээ. Манжийн хууль ёсоор Монголын засаг хан, чин ван, жүн ван, бэйл, бэйс, гүнгийн хатан нарт хааны хишиг хүртээж шагнахаас гадна хатныг нас барсны дараа тусгай түшмэл томилон хөдөөлүүлэх газарт тайлга үйлдэж байв.

Түлхүүр үг: Манж, Монгол, язгууртан ноёд, хатад, өргөмжлөл

Оршил

Манж нар XVII-XVIII зуунд Өмнөд Монгол, Халх, Зүүн гарын монголчуудыг эрхшээлдээ оруулсны дараа Монголын тайж, ноёд төдийгүй тэдний хатан нарт хааны “хишиг” хүртээж, хэргэм, цол, зэрэг шагнах бодлого хэрэгжүүлж байв. Үүний нэг илрэл нь Манжийн төрөөс Монголын язгууртан ноёд, хатан нарт өргөмжлөл олгож байсан явдал юм. XVII-XX зууны эхэн үед холбогдох өргөмжлөлийн бичгүүд нь тухайн цагийн түүхийг судлах бичгийн сурвалжийн төрөлд хамаарна.

Чин улсаас Монголын язгууртан ноёд, хатан нарт өргөмжлөл олгосон үйл явц, нийгмийн үүрэг, сурвалжийн үнэ цэнэ болон Манжийн төрийн бодлогын хувирал, өөрчлөлттэй уялдуулан судалсан бүтээл одоогоор хараахан гараагүй байна. Тухайлбал, Манж Чин улсаас Монгол ноёдын хатанд олгосон өргөмжлөлийн онцлог, эрх ба үүрэг, өргөмжлөл хүртсэн хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь өөрчлөгдөж байсан уу? зэрэг асуудал бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

Манжийн төрөөс Монголын тайж, ноёдод угсаа залгамжуулах өргөмжлөл, ухуулах өргөмжлөл, хутагт хувилгаан, лам нарт Алтан навчит өргөмжлөл, шар торгон жуух өргөмжлөл, язгууртны хатанд навчит өргөмжлөл, ухуулах өргөмжлөл зэрэг хэдэн зүйлийн өргөмжлөл олгож байв. Эдүгээ Монгол улсын Үндэсний номын сан, Үндэсний Төв Архив, Үндэсний Музей зэрэг газарт Манж Чин улсаас Халх, Ойрадын язгууртан ноёд, тэдний хатан нарт олгосон 83 өргөмжлөл уг эхээрээ байгаа бол Үндэсний Төв Архивын сан хөмрөгт өргөмжлөлийн зохиосон эхүүд гол төлөв хадгалагдаж байна. Энэ нь зөвхөн бидний үзэж харсан өргөмжлөлийн тоо бөгөөд аймаг орон нутгийн музей, хувь хүний гарт бас байж магадгүй.

Өнөөгийн судалгааны түвшинд Манжийн төрөөс Монголын ноёд, тайж, тэдний хатанд олгосон өргөмжлөл Монгол улсаас гадна БНХАУ, Тайвань, Орос, Франц зэрэг орны архив, номын санд байгаа¹ нь нэгэнт тогтоогдсон юм. Тухайлбал, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн сан хөмрөгт ноёд, хатдын өргөмжлөл² цөөнгүй байгааг судлаачид тэмдэглэжээ.

Манж Чин улсын хууль цаазын бичгүүдэд туссан төрийн бодлогын салшгүй хэсэг нь хэргэм, цол, өргөмжлөл олгох явдал байв. Тиймээс уг асуудал судлаачдын анхаарлыг татсаар иржээ. Манжийн төрөөс Өмнөд Монголын язгууртан, тэдний хатан нарт олгосон өргөмжлөлийн талаарх судалгаа³ нэлээд буй бөгөөд Халх, Ойрадын ноёд, хатдын талаарх судалгаа харьцангуй бага байна.

Манж Чин улсаас Халх болон Ойрадын язгууртан ноёд, хатан нарт олгосон дараах хэдэн өргөмжлөлийг судлан шинжилж, нийтийн хүртээл болгожээ. Үүнд,

- Монгол улсын Үндэсний Музейд буй Манжийн хаанаас Халхын Ринчендорж ноёнд олгосон манж, монгол бичгийн өргөмжлөл⁴,
- Монгол улсын Үндэсний Төв Архивт буй Манжийн хаанаас Халхын Түшээт хан аймгийн Сүжигт засгийн хошууны анхны засаг ноён Сандувдоржид олгосон таван өнгийн өргөмжлөл⁵,
- Монгол улсын Үндэсний номын санд буй Манжийн төрөөс Дөрвөд Далай хан нарт олгосон угсаа залгамжлуулах өргөмжлөл⁶, ОХУ-ын ШУА-ийн Дорно Дахины гар бичмэлийн хүрээлэнгийн сан хөмрөгт буй Манжийн

¹ Энэ талаар дараах өгүүллээс дэлгэрүүлэн үзнэ үү. - Жигмэддорж, Э. “Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалж буй нэгэн өргөмжлөлийн тухай”, *Quaestiones Mongolorum Disputatae*, 5, 2009, 8-28.

² Pang, T.A. “The Imperial Patent of the Kangxi Period in the Collection of the Institute of Oriental Manuscripts, Russian Academy of Sciences”, *Written Monuments of the Orient*, 1(7), 2018, 88-95.

³ Энэ талаар дараах бүтээлүүдээс дэлгэрүүлэн үзнэ үү. Walfgang, Franke. “Patents for Hereditary Ranks and Honary Titles During the Ch’ing Dynasty”, *Monumenta Serica*. Vol.7. No.1/2 (1942), 38-67; Wang, Peihuan. “Hong Taiji’s Patent to His zhuangfei Concubine Bumbutai”, *Beitrage zur Geschichte, Sprache und Kultur der Manchuren und Sibe*. Aetas Manjurica 6, 1998, 145-155; 杜家骥《清朝满蒙联姻研究》北京：人民出版社, 2003; Veronika, Veit. “A set of 17th to 19th Century Manchu-Mongolian Patents for Hereditary Ranks and Honorary”, *Tumen jalafun jece akū. Manchu Studies in Honour of Giovanni Stary*. Tunguso Sibirica 20, 2006, 245-253 гэх мэт.

⁴ Түвшинтөгс, Б. “Манжийн хааны нэгэн өргөмжлөлийн тухай”, 2009, 121; Түвшинтөгс, Б. “Манжийн хааны нэгэн өргөмжлөл түүх, хэл бичгийн дурсгал болох нь”, *ALTAICA*, VII, 2011, 29-47.

⁵ Жигмэддорж, Э. “Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалж буй нэгэн өргөмжлөлийн тухай”, *Quaestiones Mongolorum Disputatae*, 5, 2009, 8-28

⁶ Jigmeddorj, E. “The Certificate on title Inheritance written in Manchu and Mongolian text given to Dürbed Dalai khan by Qing dynasty”, *Oyirad Studies*, 3, 2017, 9-27.

хаанаас Халхын засаг хошууны бэйс Сондовдоржийн хатанд олгосон манж, монгол бичгийн өргөмжлөл⁷ зэргийг тус тус судалжээ.

Өмнөх судалгаанаас харахад судлаачид гол төлөв Манжийн төрөөс Монголын язгууртан ноёд, тайж нарт олгосон өргөмжлөлд анхаарал хандуулсан бөгөөд хатанд өгсөн өргөмжлөлийн талаарх судалгаа хомс ажээ.

2019 онд Монгол улсын Үндэсний номын сангийн гар бичмэлийн хөмрөг, Үндэсний Төв Архивын сан хөмрөгт буй Манжийн хаад болон Богд Жавзандамба хаанаас язгууртан ноёд, хатадад олгосон өргөмжлөл, дархан жуух бичгүүдийн гэрэл зургийг хэвлэн нийтэлсэн нь энэ талын судалгааг урагш ахиулах нэгэн алхамыг нээв⁸.

Монгол улсын хувьд Үндэсний номын санд Манжийн үед холбогдох хамгийн олон өргөмжлөл эх хувиараа байгаагийн дотор хатад, эмэгтэйчүүдэд олгосон 17 өргөмжлөл байна. Үндэсний номын санд буй хатдын өргөмжлөл нь он цагийн хувьд XVIII зууны дунд үеэс XIX зууны сүүл үед холбогдох бөгөөд манж, монгол, хятад зэрэг үсгээр бичсэн эвхмэл (12 ширхэг), хуйлмал (5 ширхэг) хоёр төрөл ажээ.

Манжийн үеийн Монголын язгууртан ноёдын хатад, эмэгтэйчүүдийн талаарх түүхийн мэдээ баримт харьцангуй хомс байдаг учир өргөмжлөлийг судлан шинжлэх нь Манжаас монголчуудын талаар явуулсан бодлого, Чин улсын цол, хэргэм шагнах тогтолцоо, хатдын намтар, өв өвлөх ёсон, овгийн нэр, гэр бүлийн уламжлал, худ ургийн харилцаа зэрэг өргөн хүрээний асуудлыг судлахад зохих ач холбогдолтой.

Энэ өгүүлэлд Монгол Улсын Үндэсний номын санд буй Манжийн төрөөс Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогт, Магсаржавын их хатан залахус овогтонд олгосон навчит өргөмжлөлийг судлан шинжлэхийг зорив.

1. Хатадын өргөмжлөлийн эх бичгийн онцлог, галиг, хөрвүүлэг

А. Манжийн төрөөс Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогтонд олгосон навчит өргөмжлөл.

Монгол Улсын Үндэсний номын санд буй Манжийн төрөөс Дөрвөдийн хан Сономгомбын их хатан Хүндчанар овогтонд олгосон навчит өргөмжлөл нь эвхмэл хэлбэртэй, 38х19 см хэмжээтэй, шугамдаж бэлтгэсэн шар өнгийн цардмал цаасан дээр манж бичгээр бичиж, хүрээг луут хээгээр чимэглэж, бичгийн эхэнд хос луу зурж, бичээсийн хойно он, сар, өдөр тавьж, тамга дарсан байна.

Өргөмжлөлийн гадна нүүрний зүүн дээд өнцөгт цагаан өнгийн жижиг цаасан дээр 8124/96 9(51) n-887 гэсэн бүртгэлийн дугаарыг цэнхэр өнгийн балаар, дунд хэсэгт “Дөрвөдийн хан Сономгомбын хатан Хүндчанар овогтын өргөмжлөл” хэмээн хар өнгийн балын харандаагаар монгол бичгээр бичиж, “Улсын номын сан”, “Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгийн номын сан (Asiatic)” гэсэн бичиг бүхий хоёр төрлийн тамга даржээ (хавсралт 1). Эдгээр нь өргөмжлөлд анхнаасаа байсан бус хожим Монгол улсын Үндэсний номын сангийн

⁷ Pang, T.A. “A Manchu-Mongolian Diploma Given to the Wife of Mongolian Nobleman”, *Written Monuments of the Orient*, 1(1), 2015, 78-86.

⁸ *Хаадын зарлиг, өргөмжлөл, жуух бичиг*. Эмхэтгэж, тодорхойлолт бичиж, хөрвүүлсэн Н.Хатанбаатар нар. Улаанбаатар: Адмон, 2019

бүртгэлд оруулах үед нэмж бичсэн нь бичгийн хэв, тиг зурлага, тамганы бичээс зэргээс тодорхой харагдана.

Дөрвөдийн хан Сономгомбын хатан Хүндчанар овогтонд олгосон навчит өргөмжлөл нь 16 мөр бүхий манж бичгээс бүрдэх бөгөөд эх бичигт *abqai* (тэнгэрийн), *hûwangdi* (хуанди) гэсэн үгийг мөр тэтгэн бичжээ⁹. Үүнд,

“abqai hesei foryon-be aliha / hûwangdi hese. han niyalma. fïyanji daliqû-i aisilara-de aydaha-be dahame / cõhome wang fungnere-be deribuhebi. gurun-de hûwaliyasun gïnggun-i qooli-be / wesihulere-be dahame. urunaqû dorgi taçihïyan-be ujelehebi. boode açabufi / sain-be yongkiyaçi. jergi-be dahame wesihun-be isibure giyan durbed-i / han sonomyombu-i fujin kutučinan halangya si. banin tob sain mujilen / gïnggun olhoba. wesihun boode banjifi. dorgi durun-be dahame jurcëhengge / aqû han-de holbofi hehei doro-be yooni aqûmbuha fïyanji daliqû-i / gungge cõlyorome iletulehengge. yargïyan-i dorgideri aisilaha ambula turgun / tudtu simbe durbed-i han-i fujin fungnefi. abdangya fungnehen buhe wesihun / miyamiyan-i ten-de isinaha. elden boçongyo etuku-de tuçike irgebun-i / nomun-de fujurungya saiqaan-be maytahabi. sain yabun-be iletuleme / mutebu jïjungge nomun-de elhe jekdun-be tuçibuhebi. ijishûn erdemu-be / ele wesihule dasara teysilere-be heulederaqû oçi hûturi kesi-be / uhei alimbi. gïnggule: / abqai wehiyehe orin uyuçi aniya joryon biyai juwan uyun.”

ХЭМЭЭЖЭЭ.

Өргөмжлөлийн эх бичгийг үндэслэвэл Манжийн төрөөс Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогтонд Тэнгэрийн тэтгэсний 29-р (1764) он өвлийн сүүл (арван хоёр) сарын арван есний өдөр навчит өргөмжлөл олгожээ. Энэ нь нийтийн он тооллын 1765 оны 1-р сарын 10-ны өдөр¹⁰ болно.

Өнөөг хүртэл хадгалагдаж үлдсэн Манжийн хаадаас Халх, Ойрадын язгууртан ноёдын хатад, эмэгтэйчүүдэд олгосон өргөмжлөлийн бичгүүд XVIII зууны дунд үеэс XIX зууны сүүл үед холбогдох юм. Иймд Дөрвөдийн хан Сономгомбын хатан Хүндчанар овогтын навчит өргөмжлөл нь Манжийн төрөөс Ойрадын язгууртан ноёдын хатан нарт хааны “хишиг” хүртээж эхэлсэн эхэн үеийн өргөмжлөлийн нэг ажээ.

Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогтын навчит өргөмжлөл нь он цагийн хувьд эдүгээ мэдэгдэж буй хатдын өргөмжлөлийн дотор харьцангуй эхэн үед холбогдох тул Манж Чин улсаас Монгол ноёдын хатанд олгосон өргөмжлөлийн төрөл, эх бичиг, найруулга, үгийн сан зэргийг харьцуулан судлах үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болох юм.

⁹ Өргөмжлөлийн манж бичгийг галиглахдаа МУИС-ийн монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн баримталдаг манж галигаар бичив.

¹⁰ Манжийн хаадын оны тооллыг нийтийн он тоололд харьцуулахдаа Оросын эрдэмтэн В.В.Цыбульский бүтээлийг тулгуур болгов. Үзнэ үү. *Цыбульский, В.В. Лунно-солнечный календарь стран Восточной Азии с переводом на даты европейского календаря*, 336.

Б.Манжийн төрөөс Дөрвөдийн хан Магсаржавын их хатан залахус овогтонд олгосон навчит өргөмжлөл.

Монгол улсын Үндэсний номын санд буй Манжийн төрөөс Дөрвөдийн хан Магсаржавын их хатан залахус овогтонд олгосон навчит өргөмжлөл нь эвхмэл хэлбэртэй, 31.5х20 см хэмжээтэй, шугамдаж бэлтгэсэн шар өнгийн цардмал цаасан дээр манж, монгол бичгээр бичиж, хүрээг луут хээгээр чимэглэж, бичгийн эхэнд хос луу зурж, бичээс тус бүрийн хойно он, сар, өдөр тавьж, тамга дарсан байна (хавсралт 1).

Өргөмжлөлийн гадна нүүрний зүүн дээд өнцөгт цагаан өнгийн жижиг цаасан дээр 8059/96 9(51) п-887 гэсэн бүртгэлийн дугаарыг цэнхэр өнгийн балаар, дунд хэсэгт “Дөрвөдийн хан Магсаржавын хатан Залахус овогтын өргөмжлөл” хэмээн хар өнгийн балын харандаагаар монгол бичгээр бичиж, “Улсын номын сан”, “Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгийн номын сан (Asiatic)” гэсэн бичиг бүхий тамга даржээ (хавсралт 2). Эдгээр нь өргөмжлөлд анхнаасаа байсан бус хожим хэн нэгэн хүн нэмж бичсэн нь бичгийн хэв, тиг зурлага, тамганы бичээс зэргээс тодорхой ойлгогдоно.

Өргөмжлөлийн эхэнд манж бичгээр 18 мөр, дараагаар монгол орчуулгыг 21 мөрөөр бичсэн бөгөөд эх бичигт тухайн үеийн албан бичгийн нэгэн адил *abqai* буюу *tingri-yin* (тэнгэрийн), *hûwangdi* буюу *quwangdi-yin* (хуандийн) гэсэн үгийг мөр тэтгэжээ. Үүнд,

Манж бичгээр:

“abqai hesei forγon-be aliha / hûwangdi hese. han niyalma. fiyanji daliqû-i aisilara-de aydaha-be / dahame čohome wang fungnere-be deribuhebi. gurun-de hûwalijasun / ginggun-i qooli-be wesihulere-be dahame urunaqû dorgi tačihayan-be / ujelehebi. boode ačabufi sain-be yongkiyači jergi-be dahame / wesihun isibure giyan. durbed-i han maysurjab-i da fujin / jalahûs halangya. sini banin tob sain. mujilen ginggun olhoba. / wesihun boode banjifi. dorgi durun-be dahame jurčehengge aqû / wang-de holbofi hehei doro-be yooni aqûmbuha fiyanji daliqû / gungge čolyorome iletulehengge. yargiyan-i dorgideri aisilaha ambula / turgun tudtu simbe durbed-i han-i fujin fungnefi. hoošan-i / abdangya fungnehen buhe wesihun miyamiyan-i ten-de isinaha. / elden bočongγo etuku-de tučike. irgebun-i nomun-de fujurungya / saiqaqan-be maytahabi. sain yabun-be iletuleme mutebu jijungge / nomun-de elhe aydun-be tučibuhebi. ijishûn erdemube / ele wesihule dasara teγsilere-be heulederaqû oči hûturi / kesi-be uhei alimbi. ginggule: / abqai wehiyehe dehi uyuči aniya joryon biyai juwan uyun.”

Монгол бичгээр:

“tngri-yin bosoy-iyar čag-i ejelegsen. / quwangdi-yin jarliy. qayan kümün, tüsiy-e tulay-a ber tusalalui-dur / itegegsen-ü tulada, tuslan wang ergümjileküi-yi egüsgejüki, olan-dur / nayiramdaqu kičiyengküi-ber qayuli-yi erkimleküi-yin tulada sayar ügei / dotoyadu suryal-i kündütegejüki, gerte nayiraqulju sayin-i / tegüsgebesü, jerge-yi dayaju erkim-i kürtegeküi jokistai bui, / dörbed-ün qan maysurjab-un yeke qatun jalaqus obuytai, činu / törölki inu, töb sayin, sedkil inu kičiyenggüi ayumdaqu, / erkim gerte törüged dotoyadu kib-i qayaju, eteged boluysan / ügei wang-dur qolbuyad, qaduytai yoson-i čöm güiçedkebei / tüsiy-e tulay-a-yin güng šilayarču ileregsen anu üneker / dotoqur-iyar yekede tusalaysan-u šiltayan bolai, teyin-kü / čimayi dörbed-ün qan-u qatun ergümjileged, čayasun-u / nabčitu ergümjilel soyorqabai, erkim čimeg-ün toyil-dur / kürbei, gerel önggitü debel-dur yarbai, šilüg-ün / nom-dur üjeskülemtü sayiqan-i maytajuqui sayin yabudal-i / ilerkilejü bütügededü, jiruqasutu nom-dur amurlingui / itegeltü-yi yaryajuqui, indei erdem-i ilanγuy-a tasulan, / jasaqu ba tegsileküi-yi ese osoldabas, buyan kesig-i / бүгүдегер күртемүи, kičiyenggüile, / tngri-yin tedkügsen-ü döčün yisüdüger on ebül-ün segül sar-a-yin arban yisün.”

Орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлбэл:

“Тэнгэрийн бошгоор цагийн эзэлсэн / хуандийн зарлиг, хаан хүмүүн түшээ тулгаар туслахад / итгэсний тулд туслан ван өргөмжлөхүйг үүсгэжүхүй, олонд/найрамдах хичээнгүйгээр хуулийг эрхэмлэхүйн тулд саар үгүй/дотоод сурталыг хүндэтгэжүхүй, гэрт найруулж сайныг / төгсгөвөөс зэргийг дагаж эрхэмийг хүртээх зохистой буй, / Дөрвөдийн хан Магсаржавын их хатан Залахус овогтой чиний / төрөлх нь төв сайн, сэтгэл нь хичээнгүй, / эрхэм гэрт төрөөд дотоод хэвийг дагаж, этгээд болсон / үгүй ванд холбоод, хадагтайн ёсыг цом гүйцэтгэвэй, / түшээ тулгын гүн шалгарч илэрсэн нь үнэхээр / дотуураар ихэд тусалсны шалтгаан болой, тийнхүү / чамайг Дөрвөдийн ханы хатан өргөмжлөөд, цаасны / навчит өргөмжлөл соёрхов, эрхэм чимэгийг туйлд / хүргэв, гэрэл өнгөт дээлэнд гарав, шүлгийн / номд үзэсгэлэнт сайхныг магтажүхүй, сайн явдлыг / илэрхийлж бүтээгээд, ном дор амирлангуй / итгэлтийг гаргажүхүй, эндүү эрдэмийг ялангуяа таслан / засах ба тэгшилэхүйг эс осолдвоос буян хишгийг / бүгдээр хүртмөй, хичээнгүйл. Тэнгэрийн тэтгэсний 49-р (1784) он өвлийн сүүл сарын арван есөн”

хэмээжээ.

Үүнийг үндэслэвэл, Манжийн төрөөс Дөрвөдийн хан Магсаржавын их хатан залахус овогтонд Тэнгэрийн тэтгэсний 49-р (1784) он өвлийн сүүл сарын арван есний өдөр навчит өргөмжлөл олгожээ. Манжийн Тэнгэрийн тэтгэсний 49-р (1784) он өвлийн сүүл сарын арван есний өдөр нь нийтийн он тооллын 1785 оны 1 сарын 29-ний цагаан хулгана (geng zi) өдөр ажээ¹¹.

¹¹ Цыбульский, В.В. Лунно-солнечный календарь стран Восточной Азии с переводом на даты европейского календаря, 339.

Бидний олж үзсэнээр Монгол улсын Үндэсний номын сан, Үндэсний Төв архивт буй Манжийн төрөөс Монголын язгууртан ноёдын хатан нарт олгосон өргөмжлөлийн эх бичиг нь дан манж бичгээр, манж - монгол бичгээр, манж - монгол - хятад ханз үсгээр, манж-хятадаар бичсэн зэрэг хэдэн янз байна. Жишээ нь: Манжийн хаанаас 1764 онд Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогтонд олгосон навчит өргөмжлөл дан манж бичгээр, 1785 онд Магсаржавын их хатан залахус овогтонд өгсөн навчит өргөмжлөл манж, монгол бичгээр, 1879 онд Халхын Сэцэн хан Цэрэндоржийн хатанд олгосон өргөмжлөлийг манж болон хятад ханз үсгээр бичжээ.

Монгол улсын Үндэсний номын санд буй XVIII-XIX зууны үед холбогдох өргөмжлөлийн эх бичгүүдээс харахад, Манж Чин улсаас Ойрадын язгууртан ноёдын хатан нарт анх дан манж бичгээр бичсэн өргөмжлөл өгч байгаад дараагаар манж, монгол бичгийн, сүүл үед манж, монгол, хятад болон манж, хятад ханз үсэг бүхий өргөмжлөл олгох болсон бололтой. Энэ нь Манж Чин улсын цол, хэргэм шагнах төрийн бодлогын зарим өөрчлөлтийг харуулах жишээ гэлтэй.

2. Хатадын өргөмжлөл ба Манжийн төрийн бодлого

Манж Чин улсын эзэн хаад төрийг удирдан жолоодох лугаа уялдан ван өргөмжлөхүйг үүсгэсэн агаад “... олонд найрамдах хичээнгүйгээр хуулийг эрхэмлэхүйн тулд ... дотоод сурталыг хүндэтгэж”, “... сайныг төгсгөвөөс зэргийг дагаж эрхэмийг хүртээх зохистой ...” хэмээх сургаалыг баримтлан өөрийн эрхшээлд буй газар орны язгууртан ноёд, тайж нар, хатад, эмэгтэйчүүдэд хэргэм, цол, зэрэг шагнах, өргөмжлөл хүртээж байв.

Монгол улсын Үндэсний номын сан, Үндэсний Төв архив болон ОХУ-ын ШУА-ийн Гар бичмэлийн хүрээлэнгийн номын сан зэрэг газарт буй XVIII-XIX зууны үед холбогдох Монголын язгууртан ноёдын хатан нарын өргөмжлөлийн уг эхэд *abdangga fungnehen* (навчит өргөмжлөл), *ulhibure fungnehen* (ухуулах өргөмжлөл) хэмээн бичсэн хоёр төрлийн өргөмжлөл тохиолдоно. Манжийн төрөөс навчит өргөмжлөлийг Монголын хан, чин ван, жүн ван, бэйл, бэйсийн хатан болон тавнангийн гэргий нарт, ухуулах өргөмжлөлийг улсын түшээ гүн, улсад туслагч гүнгийн хатанд олгож байжээ.

Манжийн хууль ёсоор дотоод, гадаад засаг, хан, вангийн хатан, бэйл, бэйсийн ноёхон, тайж, тавнангийн гэргий нарт олгуулваас зохих навчит өргөмжлөл, олгуулах зарлигийг журганаас харьяат чуулганы даргад хүргүүлж, чуулган даргын газраас тархаан олгож байсан аж. Энэ тухай “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг”-ийн хорин гуравдугаар дэвтэрт:

“Нэмж зохиосон нь. Өргөмжилсөн хатан, гэг нарт навчит өргөмжлөлийг тархаан өгөх нь. Өргөмжилсөн дотоод гадаад засаг хан вангийн хатан, бэйл, бэйсийн ноёхон, тайж, тавнангийн гэргий жич гэг нарт олгуулваас зохих навчит өргөмжлөл, олгуулах зарлигыг журганаас харьяат чуулганы даргад хүргүүлж, уламжлан тархаан олгуул. Түшмэл гаргаж хүргүүлэхийг хэрэгсэхгүй болгуул. Олон харьяат чуулганы дарга хүлээн авсан навчит өргөмжлөл, олгуулах зарлигийн тухай өдөр, жич уламжлан тархаан өгсөн, хурааж авсан өдрийг ялган салгаж тодорхойлон гаргаж журганд мэдүүлж хянан байцаагтун”¹²

гэжээ.

¹² Jarliy-iyar toγtaγaysan γadayadu mongγol-un törü-yi jasaqu yabudal-un yamun-u qauli jüil-ün bičig, qorin γurbaduyar debter, 434.


Эндээс үзэхэд эхэн үед Манжийн хааны зарлигаар өргөмжилсөн хатан, гэг нарын өргөмжлөлийг тусгай түшмэл томилон хүргэж байснаа дараа нь чуулган даргын газар үүнийг хариуцаж, тархаан өгсөн болоод хураан авсан өдрийг ялган салгаж, Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд мэдүүлж, байцаалгах болжээ.

Манжийн үед холбогдох баримтуудаас үзэхэд, *cin wang*-ийн эхнэрт *qosoi qatun*, *jüin wang*-ийн эхнэрт *törö-yin qatun*, *beyile*-ийн эхнэрт *törö-yin beyile-yin qatun*, *beyise*-ийн эхнэрт *qosigun-u beyise-yin qatun*, *güng*-ийн эхнэр *noyaqan* хэмээх цол шагнан өргөмжлөл олгодог байсан нь ихэд түгээмэл байна¹³.

Манж Чин улсын “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг”¹⁴-ийн хорин гуравдугаар дэвтэрт бичсэнээр хааны зарлигаар өргөмжлөл хүртэгсэд нь уг авсан өргөмжлөлийн бичгийг хичээнгүйлэн хадгалах бөгөөд хэрэв гал, ус, хулгайд гээгдэх, жил удаж үсэг балархай болох аваас дахин олгож байв.

Бидний өгүүлэн бүхий өргөмжлөлд нэр дурьдагдсан Дөрвөдийн хан Сономгомбо, Магсаржав нарын уг гарлыг хөөн үзвэл, Сономгомбо бээр Ойрадын язгууртан цорос овгийн Цэрэнгийн ахмад хөвгүүн бөгөөд Магсаржав бол Сономгомбын ууган хүү юм.

Схем 1. Дөрвөдийн хан Сономгомбо, Магсаржав нарын уг гарал



болно.

¹³ Удаанжаргал, Ч. “Чин улсын төрөөс Монголын язгууртан эмэгтэйчүүдэд олгож байсан цол, өргөмжлөл: эрх зүйн орчин ба нийгмийн ёс суртахуунд нөлөөлсөн нь”, *Historia Mongolarum*, 2019, 87.

¹⁴ *jarliγ-iγar toytaγaysan γadaγadu mongγol-un törü-yi jasaqu yabudal-un yamun-u qauli jüil-ün bičig, qorin γurbaduyar debter.*

Манжийн албан түүхийн нэг “Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл”-т тэмдэглэснээр Цэрэн 1753 онд Манж Чин улсад дагаар орж, чин ван хэргэм хүртсэн бөгөөд Манжийн хаан түүнд 1755 онд “Дөрвөдийн Төгс хүлэг хан” цол олгосон байдаг. Тус сурвалжид бичсэнээр Цэрэн “...эхнээс адаг хүртэл үнэнийг гаргаж зүтгэн явж, нутгийн олныг баримтлан захирч...”¹⁵ байсан ажээ. Иймд түүний хэргэм, цолыг үр хөвгүүдэд нь залгамжуулсан амуй.

Цэрэнг нас барсны дараа ахмад хөвгүүн Сономгомбо Тэнгэрийн тэтгэсний 23-р (1758) оны хаврын сүүл сард Төгс хүлэг Далай хан цолыг залгамжилж, Дөрвөд Далай ханы хошууны засаг ноёны тушаалд суужээ. Энэ талаар Манжийн төрөөс Дөрвөдийн Цэрэн, Сономгомбо, Магсаржав, Цэвээнравдан, Ламжав, Цэвээнбалчуг нарт олгосон угсаа залгамжлуулах өргөмжлөлөөс харж болмуй¹⁶. “Илтгэл шастир”-т бичсэнээр Манжийн хаан бээр Сономгомбод эцгийн хэргэм, цолыг залгамжлуулахын хамт “...дагалдаагаар чуулганы дарга тавьж, нутгийн хэргийг хичээж сурагтун”¹⁷ хэмээн зарлиг буулгажээ.

Дөрвөд Далай ханы хошуу (Дөрвөдийн зүүн гарын чуулган, Төгс хүлэг Далай ханы аймаг, Дөрвөд Далай ханы хошуу)-нд одоогийн Монгол Улсын Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Түргэн сум бүтнээр, Давст, Цагааннуур (Баян-Өлгий аймгийн Ногооннуур) сумдын хагас нутаг хамрагдана¹⁸.

Сономгомбо “Дөрвөдийг шинэ нутагт суурьших засаг захиргааны нэгжүүдийг зохион байгуулахад зүтгэл гаргаж байжээ. 1759 онд Заг, Байдрагийн газраас Увс нуурын газарт дөрвөд, баядуудыг нүүлгэн шилжүүлэх Манжийн хааны зарлиг ёсоор шинэ нутгийг эзэмших явцдаа Тагна Тувагийн урианхайчуудтай идэвхтэй харилцаж, 1769 онд нас барсан”¹⁹ ажээ.

Манж Чин улсаас 1769 онд Сономгомбын хөвгүүн Магсаржавыг засаг, Төгс хүлэг хан өргөмжилсөн бөгөөд хожим Тэнгэрийн тэтгэсний 47-р (1782) он намрын сүүл сарын арван гурванд Манжийн хаан зарлиг буулгаж, засаг, Төгс хүлэг ханы хэргэмийг үе улиран тасралгүй залгамжлуулах болжээ.

Тэнгэрийн тэтгэсний 47-р (1782) оны намраас Дөрвөдийн Сайн заяатын зүүн гарын Бат ерөөлт Төгс хүлэг Далай хан аймгийн Дөрвөд далай ханы хошууны засаг ноёд “Төгс хүлэг хан” хэргэм болон засаг тушаалыг XX зууны эхэн хүртэл үе улиран залгамжилжээ.

Өргөмжлөлийн бичигт нэр дурьдсан Дөрвөдийн хан нарын намтар, түүхийг өгүүлсний учир нь, Манж Чин улсын үед хааны зарлигаар “хишиг” хүртээх буюу Монгол ноёдын хатан нарт өргөмжлөл олгохдоо тухайн язгууртны цол, хэргэм болон хатны уг язгуур, төрөлх зан чанарыг харгалзан үздэг байжээ. Жишээ нь: Дөрвөдийн хан Сономгомбын хатан (*fujin*) болон Магсаржавын их хатан (*da fujin*) нарт олгосон өргөмжлөлд тэмдэглэснээр тэд “эрхэм гэр” буюу язгууртны гэр бүлээс гаралтай ажээ.

Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогт, Магсаржавын их хатан

¹⁵ jarliy-iyar toytaγaysan γadayadu mongyol qotun ayimay-un wang güng-üd-ün iledkel šastir, yeren jirγuduγar debter, šastir-un nayaduγar, jasay tegüs külüg dalai qan čering-un oladburi-yin šastir, 9b.

¹⁶ Энэ талаар дараах өгүүллээс дэлгэрүүлэн харна уу, Jigmeddorj, E. “The Certificate on title Inheritance written in Manchu and Mongolian text given to Dürbed Dalai khan by Qing dynasty”, 9-27.

¹⁷ jarliy-iyar toytaγaysan γadayadu mongyol qotun ayimay-un wang güng-üd-ün iledkel šastir, yeren jirγuduγar debter, šastir-un nayaduγar, jasay tegüs külüg dalai qan čering-un oladburi-yin šastir, 10a.

¹⁸ Сономдагва, Ц. *Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-2013)*, 315.

¹⁹ Сүхбаатар, На. *Баруун хязгаарын нийгэм-улс төрийн хөгжлийн түүхэн тойм*, 101.

залагус овогт нар нь “эрхэм гэрт төрөөд” ёсыг сайтар сахиж, сайнаар явсан учир Манж Чин улсаас хааны хишиг хүртээн “Дөрвөдийн ханы хатан” өргөмжилж, навчит өргөмжлөл хүртжээ. Манжийн хааны зарлигаар навчит өргөмжлөл олгох хатан бээр төрөлх нь төв сайн, сэтгэл нь хичээнгүй бөгөөд эрхэм гэрт төрөөд хадагтайн ёсыг цөм гүйцэтгэсэн байх учиртай ажээ. Энэ бол Манж Чин улсаас Монгол ноёдын хатан нарт өргөмжлөл олгохдоо тодорхой шалгуур тавьж байсны гэрч юм.

Монгол улсын Үндэсний Номын санд буй XVIII-XIX зууны үед холбогдох хатдын өргөмжлөлийн уг эхэд “их хатан”, “авааль хатан”, “уг авсан хатан” хэмээн тэмдэглэсэнээс үзэхэд, Манжийн төрөөс Монголын тайж, ноёдын анх ёслон авсан язгуур угсаа бүхий хатан нарт гол төлөв цол, өргөмжлөл шагнаж байжээ. Үүнд, Дөрвөдийн хан Магсаржавын их хатны өргөмжлөлөөс гадна Халхын Сэцэн хан Махширын авааль хатан, Дөрвөдийн хошой чин ван Гүржавын уг авсан хатны өргөмжлөл зэргийг дурьдаж болмуй.

“Илтгэл шастир”-т Дөрвөдийн хан Сономгомбын хатны тухай “...түүний хатан Бунидарь хэмээгч Халхын охин мөн буюу...” хэмээгээд Халхын чин ван Цэнгүнжавын “төрлийн охин”²⁰ гэж бичсэн байдаг. Тус сурвалжийн мэдээгээр Дөрвөдийн Цэдар тэргүүтэй 14 хүн Сономгомбын хатан Бунидарыг муу үгээр гүтгэн унагааж, Халхад эгүүлсүгэй хэмээсэн хэрэг өдөөсөн тул тэднийг шүүн хэлэлцэж, Фужиэн, Гуандунд цөлж, өрх, малыг цөм Сономгомбод шагнасан аж.

Монгол улсын Үндэсний номын санд буй Дөрвөдийн төгс хүлэг хан Сономгомбо, Магсаржав нарын өргөмжлөл болон тэдний хатанд олгосон навчит өргөмжлөлөөс дараах дүгнэлтийг хийж болох юм. Манж Чин улс дагаар ирсэн Ойрадын нөлөө бүхий язгууртан Цэрэнд чин вангийн хэргэм шагнаж, Дөрвөдийн төгс хүлэг хан өргөмжилсөн бөгөөд түүнийг нас барсны дараа хэргэм, цолыг хөвгүүн Сономгомбо, ач хүү Магсаржав нарт үе улиран залгамжлуулсны зэрэгцээ тэдний хатан нарт хааны “хишиг” хүртээж, өргөмжлөл олгох бодлого хэрэгжүүлжээ. Энэ бол Манж Чин улс дагаар орсон газар орныг төвшитгөх, Монголын язгууртан ноёдыг өөртөө татах, Манжийн төр урт удаан хугацаанд орших тогтнох бодлоготой холбоотой ажээ.

Манжийн хааны зарлигаар өргөмжлөл хүртсэн Монгол язгууртан ноёдын хатад, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, зэрэг зиндаанд ямар өөрчлөлт гарч байсан бэ? гэдэг асуудал сонирхолтой юм.

Дөрвөдийн хан Сономгомбо болон Магсаржавын их хатан нарын навчит өргөмжлөлийн эх бичгээс үзэхэд, Манж Чин улсын цол, хэргэм шагнах төрийн бодлогод Монголын язгууртан ноёдын хатад чухал байр суурь эзэлж байжээ. Тэд язгууртны гэр бүлд төрж, хэргэм, цол бүхий тайж, ноёдын хатан болж, Манжийн хааны “хишиг”-ийг хүртсний хувьд Монголын нийгмийн дээд давхаргад хамаарч байсан юм.

Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгмийн дээд давхрааны гол цөм нь болсон засаг ноёд нь Боржигон, Цорос, Торгууд, Урианхан, Их Мянгад 5 овгоос төрөн гарагсад байсан бөгөөд тэдний дотроос тоо олон, нөлөө ихтэй хэсэг нь Чингис, түүний дүү нарын угсааны Боржигин ноёд байжээ²¹. Өөрөөр хэлбэл, XVII-XX зууны эхэн үеийн Монголын язгууртан ноёд болон тэдний хатан нар

²⁰ Jarliy-iyar toytayaysan yadayadu mongyol qotun ayimay-un wang güng-üd-ün ilekkel šastir, yeren jiryuduyar debter, šastir-un nayaduyar, jasya tegüs külüg dalai qan čering-un oladburi-yin šastir, 13a.

²¹ Монгол улсын түүх, дөтгөөр боть, 178.

нь нийгмийн дээд давхраанд хамаарч, Манжийн хааны хүнд “хишиг”-т багтаж, хэргэм, цол хүртэж байв.

Манжийн хааны зарлигаар өргөмжлөл хүртсэн Монголын язгууртан ноёдын хатад тухайн үеийн засаг бус тайж нарын хатан болон бусад эмэгтэйчүүдээс дээгүүр байр суурь эзэлж байсан юм. Манжийн хууль ёсоор Монголын засаг хан, чин ван, жүн ван, бэйл, бэйс, гүнгийн хатан нарт хааны хишиг хүртээж шагнахаас гадна нас барсны дараа тусгай түшмэлийг томилон хүүрийн газарт тайлга /тайх/ үйлдэж байв. Энэ тухай: “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг”-ийн хорин зургаадугаар дэвтэрт тусгайлан заасан байдаг. Тухайлбал,

“Шагнан тайх нь. Залруулан зассан нь: Шагнан тайх тогтсон хууль. Нэгэн зүйл. Дотоод гадаад засаг хан хан, чин ван, жүн ван, хан вангийн шижи, бэйл, бэйлийн ахмад хөвгүүн, гүн, улсын эфү, хошой эфү, хошой гээгийн эфү, төрийн гээгийн эфү, бэйлийн охин төрийн гээгийн эфү, хошууны гээгийн эфү, улсын гүнж, хошой гүнж, хойшой гэг, төрийн гэг, бэйлийн охин төрийн гэг, хошууны гэг, гүнгийн охин гэг, чин вангийн хатан эд цөм хууль ёсоор айлтгаж тайж илгээхээс гадна жүн вангийн хатан, бэйл, бэйсийн гүнгийн ноёдод шагнан тайлгаж болох ба үл болох явдлыг Журганаас тодорхойлон гаргаж зарлигыг гуйж айлтгагтун”²²

гэжээ.

Манж Чин улсаас Монгол хан, чин ван, жүн вангуудын хатанд цөм Дотоод яамнаас манж, монгол үсгийн тайх бичиг орчуулж, тайж илгээх түшмэлд тушаан өгч байсан бөгөөд “Аливаа монгол хан, чин вангаас доош гүнгээс дээш жич, гүнж, гэг, эфү, чин вангийн хатнаас доош гүнгийн ноёхдоос дээшийг нь тайхад тохиолдвоос үхэр, хонь, архийг Сангийн явдлын яамнаас үнэ таацуулж, тайж илгээх түшмэлд тушааж, харьяат газраа хүрээд ойрыг үзэж эрэн худалдан явхуул” хэмээн хуулинд заасан аж. Энэ дагуу аливаа гүн, сул эфү, жич төрийн гэг, бэйлийн охин төрийн гэг, хошууны гэг, гүнгийн охин гэг, жүн вангийн хатан, бэйл, бэйс гүнгийн ноёхдоо бие өнгөрвөөс өөр өөрийн харьяат газрын жанжин сайдад тушааж, тэнд суулгасан түшмэдийг гаргаж, ойрыг үзэж тайлга хэмээмэй.

Зарилгаар зарсан түшмэдийг Монгол ван гүнгүүд бүх гэрээр доорд ардын хамт угтан авч, хүүрийн газарт тайх бичгийг уншиж шагнан дуусах цагт харьяат ван гүнгүүд жич, хурж ирсэн монголчууд бүрнээ сөгдөж, ордны зүг хандаж гурвантаа сөгдөн есөнтөө мөргөх зан үйл үлдэж байжээ. Эдгээр нь Манжийн төрөөс Монгол хан, ван, бэйл, бэйс, гүнгийн хатан өргөмжлөгдсөн хатад, эмэгтэйчүүд нь хааны хишиг хүртэх онцгой эрх эдэлж байсныг харуулна.

Манжийн хуулинд харц хүн хатан лугаа явалдахыг хуулиар хориглож, “явалдваас явалдсан эрийг огтчин ал, хатныг даруй чавчин ал”²³, хамжлага албат нар тайж нарын гэргий лүгээ явалдваас явалдсан эр, эмийг хөвчдөн алах ял торгож, гянданд хорь гэх зэргээр хатуу чанга шийтгэхээр заасан байдаг.

Энэ дашрамд өгүүлэхэд, Манжийн үеийн Монгол орны эгэл жирийн

²² Jarliy-iyar toytaγaysan γadayadu mongγol-un törü-yi jasaqu yabudal-un yamun-u qauli jüil-ün bičig, qorin jirγuyaduyar debter, 283-284.

²³ Jarliy-iyar toytaγaysan γadayadu mongγol-un törü-yi jasaqu yabudal-un yamun-u qauli jüil-ün bičig, γurbaduyar debter, 624-625.

эмэгтэйчүүдийн хувьд мал, бараа мэт үнэ зохиож худалдах, ял торгуулын оронд барьж өгөх, хилс хэрэгт холбогдуулан унагааж хагацах салах, үхэх гаслан зовлонд учруулсан тохиолдол олонтой гарч байв. Жишээ нь, Монгол Улсын Үндэсний Төв Архивт Тэнгэрийн тэтгэсний 29-р (1764) онд Цахар найман хошуунаас 420 эмэгтэйг Өөлдөд худалдах тухай баримт үлджээ. Үүний дотор язгууртны хамжлага 15-аас дээш насны эрд очоогүй эмэгтэй 174, бэлбэсэн эмэгтэй 84, хошууны ардуудын эрд гараагүй 80, бэлэвсэн эмэгтэй 82 байсан²⁴ аж.

Манжийн төрөөс Монгол ноёдын хатан нарт өргөмжлөл олгох нь Чин улсын цол, хэргэм шагнах бодлогын салшгүй хэсэг болохын хувьд нийгмийн зохих үүрэгтэй байв. Энэ нь хатдын хувьд юуны өмнө ёс суртахууны үүргээр илэрч буй юм. Тухайлбал, өгүүлэн бүхий хоёр өргөмжлөлийн бичигт “...эрхэм чимэгийг туйлд хүргэв, гэрэл өнгөт дээлэнд гарав, шүлгийн номд үзэсгэлэнт сайхныг магтажухуй, сайн явдлыг илэрхийлж бүтээгээд, ном дор амирлангуй итгэлтийг гаргажухуй...” гэх мэтээр тухайн хатан бээр бүсгүй хүний ёс журмыг чанд сахиж, үлгэр жишээ байхыг ухуулан сэнхрүүлж, төгсгөлд эдгээрийг эс олдвоос хааны “...hūturī kesi-be uhei alimbi. ginggule.” (... буян хишигийг бүгдээр хүртмөй, хичээнгүйл) хэмээн бичжээ.

Хатан хүний ёс журмыг эрхэмлэх, сайн явдлыг хичээнгүйлэн дагах тухай суртлыг бусад өргөмжлөлийн бичгээс ч гэсэн харж болно. Жишээ нь: Халхын засаг хошууны бэйс Сондовдоржийн хойно авсан хатанд олгосон өргөмжлөлийн бичигт:

“...qalq-a-yin jasaγ qosiyun-u bayise sondobdorji-yin qoyitu abuγsan gergei uqaγ-a jug šeo-yin okin. čini törölki inu kičiyenggüi ayumdaqu. erdem inu dölgen tüliyen nöbür-tegen tusalaju gerte keb bayiyulju jasaqu ba tengsilekü soyul-i tegüsüged. dotuγar-iyar tusalaysan anu üneker yeke bolbai. teyin kü čamayı beyise-yin qatun ergümjileged, čaγasun-u nabčitu ergümjilel soyuqabai. beyise-dür qolbaysan anu erkim niγurtai qoyar ügei... kesig-i kürtebei kemen buu rasi γurba γdun. kičiyenggüyile”²⁵

гэх зэргээр хатан хүн бээр төрөлх нь төгс хичээнгүй, эрдэм нь дөлгөөн байж, нөхөртөө тусалж, гэртээ хэв байгуулж засах учиртайг заан сургажээ.

Манжийн төрөөс өргөмжлөл хүртсэн Монголын язгууртан ноёдын хатан нар нь хааны “хишиг”-ийг үл умартан, сайн явдлыг ихэд хичээнгүйлж, хадагтайн ёсыг чанд баримтлах үүрэгтэй ажээ.

Манжийн төрөөс өргөмжлөл хүртсэн Монголын язгууртан ноёдын хатан нар нь хааны “хишиг”-ийг үл умартан, сайн явдлыг ихэд хичээнгүйлж, хадагтайн ёсыг чанд баримтлах агаад тэдний хөвгүүд эцгийн хэргэм, цолыг залгамжилж, өв өвлөх эрхтэй байсан юм. Манжийн хуулинд эцгийн хэргэм, цол, зэргийг харгалзан хөвгүүдэд нь залгамжлуулахаар заасан бөгөөд орон гарсны хойно нэгэн хөвгүүнийг хууль ёсоор залгамжлуулаад үе улиран тасралгүй залгамжлуулж, үлсэн олон хөвгүүдийг нийтээр дөтгөөр зэрэг тайж болгож байв. Тухайлбал, “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг”-ийн гуравдугаар дэвтэрт:

²⁴ Манжийн түрэмгийлэгчдийн үе дэх Монголын эмэгтэйчүүдийн дарлагдал (1764-1833), 4-64; Бадамгарав, Ц. БНМАУ-ын эмэгтэйчүүд, хүүхэд, 8.

²⁵ Pang, T.A. “A Manchu-Mongolian Diploma Given to the Wife of Mongolian Nobleman”, 79.

“Дотоод, Гадаад засаг ба жич сул хан, чин вангийн хөвгүүнийг тэргүүн зэрэг тайж болго, жүн ван, бэйлийн хөвгүүнийг дэд зэрэг тайж болго, бэйл, гүнгийн хөвгүүнийг гутгаар зэргийн тайж болго, тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг тайжийн хөвгүүнийг цөм дөтгөөр зэрэг тайж болго, нийтээр арван найман насанд хүрсний хойно ялган салгаж зэрэг олгуулагтун”²⁶

гэж заажээ.

Ойрадын хаад, ноёд хөвгүүддээ ямар байдлаар өв залгамжуулж байсан тухай Баатар увшийн туурвисан “Дөрвөн Ойрадын түүх оршив” хэмээх тод үсгийн сурвалж бичигт:

“...dörböd dalai tayisi albutān yurbanai kēd хойур аха köbüün-dēn nige xubiyini xubāji ögüqsen :: dundu köbüün-dēn dayičang xosuučidu nigen xubiyini dangyār ögüqsen: bisi köbüüdtēn kiri kirēni xubāji ögüd: čečen gedeg köbüügen önci-ügei γarγaqsan::” (Дөрвөд Далай тайш албатаа гурав хийгээд хоёр ах хөвгүүндээ нэг хувийг нь хувааж өгсөн :: дунд хөвгүүндээ Дайчин хошуучид нэг хувийг нь дангаар өгсөн : бусад хөвгүүддээ хир хирээр нь хувааж өгөөд : Цэцэн гэдэг хөвгүүнээ өмчгүй гаргасан ::) гэсэн бол,

“...bošoqtu qan jaliq bolboi: sayin köbüün-dü önci ese ögübe-čü albutu tüünē: muu köbüün-dü yerü öqči kereq ügei: ürekü raraxu mōn: dundān köbüün-dü önci ögöyü bayiyu ...” (Бошогт хаан зарлиг болов: Сайн хөвгүүнд өмч өгөвч албат түүнийх, муу хөвгүүнд ер өгч хэрэггүй, үрээх тараах мөн. Дунд хөвгүүнд өмч өгье үү байя уу)²⁷

хэмээн зарлиг буулгасан тухай тэмдэглэжээ. Үүнээс харахад, Манжийн “Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг”-ийн зарим заалт нь монголчуудын өв өвлөх ёсны уламжлалд ямар нэгэн хэмжээгээр суурилж байсан гэлтэй.

Монголчуудын өв өвлөх ёсон ялангуяа тайж язгууртны гэр бүлийн хувьд их хатан болон түүний хүүхдүүд онцгой эрх дархтай байв. Энэ талаар “Монголын нууц товчоон” тэргүүтэй сурвалж бичиг болон Халхын Сэцэн хан Шолойн өмч хуваасан тэмдэглэл²⁸, Манжийн үеийн Монголын аймаг, хошуудын данс хараа, гэрээ бичиг зэргээс лавлан мэдэж болно. Монголын язгууртан тайж нар өөд болох аваас хатан бээр өв хөрөнгийг үр хүүхдүүддээ хуваарилан тархаах, ноёны аман эш, тэмдэг бичгийн ёсоор гүйцэлдүүлэх эрхийг мэдэж байжээ. Жишээ нь, 1778 онд Халхын Түшээт хан аймгийн Дэчинрампилын хошууны Тунгалаг хатнаас засаг ноёндоо өргөсөн тэмдэг бичигт:

“beyise noyan tan-a ekilen tusalayči kergemten-e temdeg bičig bariqui-yin učir, batulaqu-yin temdeg noyan amidu aqui čay tur-iyen degu tayiji rinčin-yin köbegün vangbudorji-yi jiγaju yavbuysan bile, edüge čay möngke ügei-yin tula bi amidu aqui čay-tur öber-iyen medejü yabuqu-ača γadan-a minu biyen-eče qoyisi tabun erü gēuy tan-a tusiyaba, tngri-yin tedkügen-ü döčin γurbaduγar on-u namarun dumda sara-yin sine-yin dörben”²⁹

ХЭМЭЭЖЭЭ.

²⁶ Jarliy-iyar toγtaγaysan γadaγadu mongγol-un törü-yi jasaqu yabudal-un yamun-u qauli jüil-ün bičig, γurbaduγar debter, 76.

²⁷ Баатар увш, *Дөрвөн Ойрадын түүх оршив*, 86-87.

²⁸ Жигмэддорж, Э. *Халх-Манжийн улс төрийн харилцаа*, 99.

²⁹ Нацагдорж. Ш. *Монголчуудын өв өвлөх эрх*, 45.

Дөрвөдийн хан Сономгомбо болон Магсаржав нар бол Дөрвөн Ойрадын нөлөө бүхий цорос овгийн язгууртан бөгөөд тэдний хатад нь *kuntučinar*, *jalayus* овогтой ажээ. Тухайлбал, Сономгомбын хатан Бунидарь нь Халхын чин ван Цэнгүнжавын төрлийн охин ажээ. Энэ нь Ойрадын язгууртны дунд өөр овгоос эхнэр авах ёс (экзагом) XVIII зуунд хэвээр хадгалагдсаар байсны гэрч юм.

Түүхээс үзэхэд, Зүүнгарын хаант улсын үед Ойрадын холбоо дотооддоо эв нэгдэлтэй байх, холбооныхоо дотоод асуудлыг шийдвэрлэхэд ураг барилдах явдлыг төрийн бодлогын хэмжээнд тавьсаар байв. Тухайн үед улс төрийн ихээхэн эрх мэдэлтэй байсан хүмүүс энэ асуудалд ач холбогдол өгч байсан нь харагддаг. Тухайлбал, Эрдэнэбаатар хун тайж Торгуудын Шүхэр дайчины охин Юм Агаг, Байбгасбаатар Торгуудын тайж нараас гаралтай Сайхан Зүй хатныг, Халимагийн Пунцаг хан Эрдэнэбаатар хун тайжийн охиныг, Хошуудын Очирт сэцэн тайж Халимагийн Пунцаг ханы охин Доржравданг, Галдан Хошуудын Галдамбаатарын охин Ануг, Хошуудын Галдамбаатар Сэнгэ хааны охин Цэвээнбүкэридийг, Сэнгэ хаан Хошуудын тайж нараас гаралтай Цэвээнжалмуг, Цэвээнравдан хаан Хошуудын Жононы охиныг, мөн Торгуудын Аюуки ханы охин Сэтэржавыг, Галданцэрэн Хошуудын Шагдарманжийн охиныг, Хошуудын Галданданжин Цэвээнравдан хааны охин Бутулаг эхнэр болгож байсан зэрэг мэдээнүүд байдаг³⁰.

Сономгомбын хатны овгийг өргөмжлөлийн эх бичигт манжаар *kutučinar* хэмээн бичжээ. Монголын олон овгийн дотор үүнтэй төстэй нэрийг шүүн үзвэл, *ködöčiner* хэмээх нэгэн нэр тохиолдоно. Энэ овгийн тухай “Монгол овгийн товчоон” бүтээлд “XIII зууны үеийн Хишигтэн цэргийн бүрэлдэхүүн доторхи нэгэн төрөл болно. *ködöčiner*, *хөтөчин* бол *хөтөчийн* олон тоог илэрхийлсэн хэлбэр. Монгол сурвалж, түүх сударт тэмдэглэснээр агт хүлэг, гэр тэрэг хөтлөх хөтөчийн алба үүрэг бүхий тушаалтай хүмүүс нэлээд хожим болтол хааны ордонд үйлчилж байжээ. Монгол улсын Ховд аймгийн Булган сумаар хөтөч, Завхан аймгийн Сонгино сум, Увс аймгийн Давст, Сагил, Бөхмөрөн сумаар хөтөчин, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум, Алтайн Монгол урианхайн дотор *ködöčiner* овогтон олонтой. Ижил мөрний Халимагын Бүгд Найрамдах улсын сурвалжит монгол овгийн нэг нь *ködöčiner*”³¹ гэжээ.

Жамсарны Цэвээн бээр XX зууны эхэн үеийн Монгол улсын баруун хязгаарын Дөрвөд Далай ханы хошуунд “хөтөч” хэмээх овог байсныг бичиж үлдээсэн³² бол А.Очир “Монголын Ойрадуудын түүхийн товч”³³ судалгааны бүтээлдээ тус хошуунд “хөтөч нар” гэдэг овог буйг тэмдэглэжээ.

Монгол улсын хууль зүйн яам болон ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс 1998 онд хэвлүүлсэн “Монголчуудын овгийн лавлах”³⁴ гарын авлагад бичсэнээр Увс аймгийн Давст, Түргэн, Сагил, Өлгий сумдад хөтөч нар, Давст, Сагил, Түргэн, Бөхмөрөн, Өмнөговь сумдад хөтчин овог тус тус бүртгэгдсэн байна. Увс аймгийн эдгээр сумдад амьдарч буй хүмүүс нь

³⁰ Сүхбаатар, На. Төрбат, Ц. “Генеологийн ухаан ба Ойрадын язгууртнуудын уг гарлын асуудалд”, 108.

³¹ Дүншиг, Ш. *Монгол овгийн товчоон*, 533.

³² Цэвээн, Ж. *Дархад, Хөвсгөл нуурын урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Цахар, Дарьганга, Алтайн урианхай, Хасаг, Хамниганы гарал үүсэл байдлын өгүүлэл*, 9.

³³ Очир, А. *Монголын Ойрадуудын түүхийн товч*, т.27

³⁴ Тайжуд Очир, Бэсүд Сэржээ, *Монголчуудын овгийн лавлах*, 40.

угсаа гарлын хувьд XVII зууны Зүүнгарын хаант улс, XVIII-XX зууны эхэн буюу Манжийн эрхшээлийн үеийн Дөрвөд далай ханы хошуунд харьяалагдаж байсан хүмүүсийн үр хойч юм.

Монгол Улсын хүн ам, өрхийн мэдээллийн санд 2020 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар “хөтөч нар” гэдэг ургийн овогтой 25 хүн бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 23, Сэлэнгэ аймагт 3 хүн³⁵ байна.

XVIII зууны үеийн Ойрадын язгууртан, Дөрвөдийн хан Сономгомбын хатны *kuntučina*г хэмээх овгийг хөтөчийн олон тоог илэрхийлсэн хэлбэр гэж үзвэл, энэ овог эдүгээ хүртэл монголчуудын дунд байна.

Дөрвөдийн хан Магсаржвын их хатны овгийг өргөмжлөлийн бичигт *jalaqus* (залахус) хэмээн бичжээ. “Монгол овгийн товчоон” бүтээлд “*Үгийн язгуур нь залуу. Залагус нь залуугийн олон тоог илтгэсэн хэлбэр. XIII зууны үест нас залуу эрэгтэй боолыг “залуу” гэж нэрлэдэг байжээ ... Гэрийн боол залуугийн хойч үе залуус овогтон болсон билээ. Монгол улсын Увс аймгийн Давст сум, Өмнөговь, Өлгий, Сагил, Ховд, Завхан, Наранбулаг, Тариалан сумын Дөрвөдийн дотор, Алтайн Монгол Урианхайн дотор залагус овогтон өргөн тархаж буй*”³⁶ гэжээ.

Монгол улсын хүн ам, өрхийн мэдээллийн санд 2020 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар “залуус”³⁷ гэдэг ургийн овогтой 8 хүн байгаа бөгөөд үүнээс Улаанбаатар хотод 7, Говь-Алтай аймагт 1 хүн бүртгэгджээ. Ийнхүү Дөрвөдийн хан Магсаржвын их хатны залагус овгийг залуугийн олон тоог илтгэсэн хэлбэр мөн гэж үзвэл, энэ овог одоо ч гэсэн монголчуудын дунд байгаа болно.

Дүгнэлт

Манж Чин улсын эзэн хаад төрийг удирдан жолоодох лугаа уялдан ван өргөмжлөхүйг үүсгэсэн агаад “... олонд найрамдах хичээнгүйгээр хуулийг эрхэмлэхүйн тулд ... дотоод сурталыг хүндэтгэж”, “... сайныг төгсгөвөөс зэргийг дагаж эрхэмийг хүртээх зохистой ...” хэмээх сургаалыг баримтлан өөрийн эрхшээлд буй газар орны язгууртан ноёд, тайж нар, хатад, эмэгтэйчүүдэд цол, өргөмжлөл хүртээж байсан нь баримтаас харагдаж байна.

Манжийн төрөөс Дөрвөдийн хан Сономгомбын хатан хөтөч нар овогтонд Тэнгэрийн тэтгэсний 29-р (1764) он өвлийн сүүл сарын арван есний өдөр (нийтийн он тооллын 1765 оны 1-р сарын 10-ны өдөр), Магсаржавын их хатан залахус овогтонд Тэнгэрийн тэтгэсний 49-р (1784) он өвлийн сүүл сарын арван есний өдөр буюу нийтийн он тооллын 1785 оны 1 сарын 29-ний цагаан хулгана (*geng zi*) өдөр тус өргөмжлөл олгожээ. Эдгээр өргөмжлөлөөс харахад, Манжийн хааны зарлигаар Монгол ноёдын хатанд өргөмжлөл олгохдоо тухайн язгууртны цол, хэргэм болон хатны уг язгуур, төрөлх зан чанарыг харгалзан үздэг байжээ.

³⁵ <https://www.1212.mn/sonirkholtoi/FamilyName/>

³⁶ Дүншиг, Ш. *Монгол овгийн товчоон*, 933.

³⁷ <https://www.1212.mn/sonirkholtoi/FamilyName/?search=%d1%85%d3%a9%d1%82%d3%a9%d1%87>

Манж Чин улс дагаар ирсэн Ойрадын нөлөө бүхий язгууртан нарт төрийн өндөр хэргэм, цол шагнаж, үе улиран залгамжлуулахын зэрэгцээ тэдний хатан нарт хааны “хишиг” хүртээж, цол өргөмжлөл олгох бодлого хэрэгжүүлжээ. Энэ бол дагаар орсон нутаг орныг төвшитгөх, Монголын бусад ноёдыг өөртөө татах, Манжийн төр урт удаан хугацаанд орших тогтнох явдалтай холбоотой байв.

Манжийн хааны зарлигаар өргөмжлөл хүртсэн Монголын язгууртан ноёдын хатад тухайн үеийн засаг бус тайж нарын хатан болон бусад эмэгтэйчүүдээс дээгүүр байр суурь эзэлж, нийгмийн дээд давхрагад хамаарч байжээ. Манжийн хууль ёсоор Монголын засаг хан, чин ван, жүн ван, бэйл, бэйс, гүнгийн хатан нарт хааны хишиг хүртээж шагнахаас гадна хатныг нас барсны дараа тусгай түшмэл томилон хөдөөлүүлэх газарт тайлга /тайх/ үйлдэж байв.

Манжийн төрөөс өргөмжлөл хүртсэн Монголын язгууртан ноёдын хатан нар нь хааны “хишиг”-ийг үл умартан, сайн явдлыг ихэд хичээнгүйлж, хадагтайн ёсыг чанд баримтлах агаад тэдний хөвгүүд эцгийн хэргэм, цолыг залгамжлах нь түгээмэл байв. Энэ талаас авч үзвэл хатдын өргөмжлөл нь монголчуудын гэр бүлийн түүхийг улируулан судлах сонирхолтой сурвалжийн нэг болж байна. Дөрвөдийн хан Сономгомбо болон Магсаржавын их хатан нарын навчит өргөмжлөлийн эх бичгээс үзэхэд, Монгол язгууртны дунд өөр овгоос эхнэр авах ёс (экзагом) XVIII зуунд хэвээр хадгалагдсаар байжээ.

Монгол улсын Үндэсний номын санд буй Дөрвөдийн хан нарын хатны өргөмжлөлийн жишээнээс харахад, Манж Чин улсын хэргэм, цол шагнах төрийн бодлогод Монголын язгууртан ноёдын хатад чухал байр суурь эзэлж байжээ.

TITLES BY QING DYNASTY TO THE WIVES OF DÜRBED KHANS SONOMGOMBO AND MAGSARJAV

Abstract: Manchurians had politics to award titles and “gratifications” to not only the Mongolian noblemen, but also their wives after subjugating Mongols in South Mongolia, Khalha and Zuungar in the XYII-XYIII centuries. For instance, the highest noblemen and their wives were awarded the titles. In this article the title “Leaf owner” given to Dürbed khan Sonomgombo’s wife who comes from Khundchanar tribe and Magsarjav’s wife who comes from Zalaqus tribe. These two title certifications were not studied before and there is some information connected with Mongolian noblemen families. As the original copies of “Leaf owner” title certificates for the elder wives of Sonomgombo and Magsarjav khans show that the wives of Mongolian noblemen played important role in the state politics. The Qing dynasty had politics to give the inheritable state high rank titles and “gratifications” not only to the high-powered noblemen from the sovereign Oyirad but also their wives. This politics aimed to bring peace in the sovereign place, to attract the Mongolian noblemen to its politics and to provide the long existence of Qing dynasty. The Qing dynasty awarded the titles to the Mongolian noblemen’s wives on the basis of the noblemen’s former titles and their wives genesis and native attitudes. The noblemen’s wives who were awarded by the Qing state with titles had not forgotten the emperor’s “gratifications” tried to do their best and be honored and their sons inherited their fathers’ titles. The noblemen’s wives who awarded the titles by the Qing emperor belonged to the highest social layer and took higher place than other noblemen’s wives in the society.

Ном зүй

Сурвалж бичиг, баримтын эмхтгэл:

1. Баатар увш. *Дөрвөн Ойрадын түүх оришв.* Латин галиг, үгийн цэс үйлдэж, кирилл бичгээр хөрвүүлэн удиртгал, тайлбар бичсэн Б.Түвшинтөгс, На.Сүхбаатар. Улаанбаатар: “Соёмбо принтинг” хэвлэх үйлдвэр, 2006
2. *jarliᠢ-yar toyᠲayaᠰan ᠶadaᠶadu mongᠭol qotun ayimaᠭ-un wang güng-üd-ün ilelkel šastir* (Япон улсын Токио их сургуулийн номын санд хадгалж байгаа модон барын хэвлэл)
3. *jarliᠢ-yar toyᠲayaᠰan ᠶadaᠶadu mongᠭol-un törü-yi ᠵasaqu yabudal-un yamun-u qauli jüil-ün bičig. altan-orᠢil qarᠭayulju tayilburilaba. öbur mongᠭol-un soyol-un keblel-ün qoriy-a*, 1989
4. *Манжийн түрэмгийлэгчдийн үе дэх Монголын эмэгтэйчүүдийн дарлагдал (1764-1833).* Эмхтгэсэн Ө.Чимэд. Улаанбаатар: Цэргийн хэвлэх үйлдвэр, 1958

Судалгааны бүтээл:

Монгол хэлээр

5. Бадамгарав, Ц. *БНМАУ-ын эмэгтэйчүүд, хүүхэд.* Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1971
6. Жигмэддорж, Э. Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалж буй нэгэн өргөмжлөлийн тухай. *Quaestiones Mongolorum Disputatae.* Vol. 5. Tokyo, 2009. p.8-28
7. Тайжуд Очир, Бэсүд Сэржээ. *Монголчуудын овгийн лавлах.* Улаанбаатар: ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн хэвлэх хэсэг, 1998
8. Дүншиг, Ш. Монгол овгийн товчоон. Ляонингийн үндэстний хэвлэлийн хороо, 2009
9. Нацагдорж, Ш. *Монголчуудын өв өвлөх эрх.* Studia Ethnographica. Tom. Iv. Fasc.6. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр, 1971
10. Сүхбаатар, На. Баруун хязгаарын нийгэм-улс төрийн хөгжлийн түүхэн тойм (XX зууны эхэн үеэс 1930-аад он). Улаанбаатар: 2000
11. Сүхбаатар, На. Төрбат, Ц. Генеологийн ухаан ба Ойрадын язгууртнуудын уг гарлын асуудалд. Түүхийн хавсрага ухаан. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2003. т.103-109
12. Түвшинтөгс, Б. Манжийн хааны нэгэн өргөмжлөлийн тухай. “*Монгол туургатны эрт ба эдүгээ*” олон улсын эрдэм шинжилгээний III чуулган. Улаанбаатар, 2009. т.121
13. Түвшинтөгс, Б. Манжийн хааны нэгэн өргөмжлөл түүх, хэл бичгийн дурсгал болох нь. *ALTAICA.* VII. Улаанбаатар, 2011. т.29-47
14. Удаанжаргал, Ч. Чин улсын төрөөс Монголын язгууртан эмэгтэйчүүдэд олгож байсан цол, өргөмжлөл: эрх зүйн орчин ба нийгмийн ёс суртахуунд нөлөөлсөн нь. *Historia Mongolarum.* Tom.XVIII. Fasc.4. Улаанбаатар: 2019. т.80-104
15. Сономдагва, Ц. *Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-2013).* Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан, С.Ичинноров, Ц.Энхээ. Улаанбаатар: 2013
16. Цэвээн, Ж. *Дархад, Хөвсгөл нуурын Урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Цахар, Дарьганга, Алтайн урианхай, Хасаг, Хамниганы гарал үндэс байдлын өгүүлэл.* Улаанбаатар: 1934

Орос хэлээр

17. Цыбульский, В.В. *Лунно-солнечный календарь стран Восточной Азии с переводом на даты европейского календаря (с 1 по 2019 г.н.э.)*. Москва: Изд., Наука ГРБЛ., 1987

Англи хэлээр


18. Atwood, C. "Worshiping Grace": The Language of Loyalty in Qing Mongolia," *Late Imperial China*, Vol. 21, No. 2 (December, 2000), 86-139
19. Atwood, C. Titles, Appanages, Marriages, and Officials: A Comparison of Political Forms in the Zünghar and Thirteenth-Century Mongol Empires. *Imperial Statecraft: Political Forms and Techniques of Governance in Inner Asia, Sixth-Twentieth Centuries*. Edited by David Sneath. Western Washington University. 2006, 207-243
20. Chieh-hsien Chen. *The Manchu Palace Memorials*. Taipei: Linking Publishing, 1987
21. Johan, Elverskog. *Our Great Qing (The Mongols, Buddhism and the State in Late Imperial China)*. Honolulu: University of Hawai'i Press, 2006
22. Jigmeddorj, E. The Certificate on title Inheritance written in Manchu and Mongolian text given to Dürbed Dalai khan by Qing dynasty. *Oyirad Studies*. Vol. 3. Budapest, 2017. pp.9-27
23. Pang, T.A. A Manchu-Mongolian Diploma Given to the Wife of Mongolian Nobleman. *Written Monuments of the Orient*. Russian Academy of Sciences. Institute of Oriental Manuscripts. 2015(1), p.78-86
24. Pang, T.A. The Imperial Patent of the Kangxi Period in the Collection of the Institute of Oriental Manuscripts, Russian Academy of Sciences. *Written Monuments of the Orient*, 1(7), 2018, 88-95
25. Walfgang, Franke. Patents for Hereditary Ranks and Honary Titles During the Ch'ing Dynasty. *Monumenta Serica*. Vol.7. No.1/2 (1942), 38-67
26. Wang, Peihuan. Hong Taiji's Patent to His zhuangfei Concubine Bumbutai. *Beitrag zur Geschichte, Sprache und Kultur der Manchuren und Sibe*. Aetas Manjurica 6, 1998, 145-155
27. Veronika, Veit. A set of 17th to 19th Century Manchu-Mongolian Patents for Hereditary Ranks and Honorary. *Tumen jalafun jece akū. Manchu Studies in Honour of Giovanni Stary*. Tunguso Sibirica 20, 2006, 245-253

Хятад хэлээр


28. 杜家骥《清朝满蒙联姻研究》北京: 人民出版社, 2003


Хавсралт 1.


Дөрвөдийн хан Сономгомбын хатан хүндчанар овогтын өргөмжлөл



Эх сурвалж: Монгол улсын Үндэсний номын сан








Хавсралт 2.

Дөрвөдийн хан Магсаржавын хатан залуус овогтын өргөмжлөл



Эх сурвалж: Монгол улсын Үндэсний номын сан

